



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatheural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2025 · 08 · 20 № 32

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, 2024 оны 53 дугаар тогтоолын талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, 2-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.”, Арван зургадугаар зүйлийн 7-д “сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно.” гэж заасан байдаг.

Мөн Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 1 дүгээр зүйлд “Хүн бүр төрөхөөсөө эрх чөлөөтэй, нэр төр, эрхийнхээ хувьд адил тэгш байна. Тэдэнд оюун ухаан, өрлөг сэтгэл заясан бөгөөд өөр хоорондоо ахан дүүгийн ёсоор харилцах ёстай.”, 2 дугаар зүйлд “Хүн бүр энэ Тунхаглалд заасан бүхий л эрх, эрх чөлөөг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлын ялгааг эс харгалзан ямар ч гадуурхалгүйгээр эдлэх ёстай. Мөн түүнчлэн тухайн хүнийг харьялдаг улс буюу нутаг дэвсгэрийн улс төр, эрх зүй болон олон улсын статус ямар ч байлаа гэсэн, тухайлбал, тусгаар тогтоносон буюу асрамжинд байгаа, өөрөө эс удирдах зэрэг бүрэн эрхт байдал нь ямар ч байдлаар хязгаарлагдмал байсан тэр нь ялгаварлах үндэс болох ёсгүй.”, 7 дугаар зүйлд “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч алагчилалгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Хүн бүр энэхүү Тунхаглалд харшлах аливаа алагчилалаас болон тийнхүү алагчилахыг өдөөсөн турхиралтаас адилхан хамгаалуулах эрхтэй.”, 26 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүн бүр сурч боловсрох эрхтэй. Наад зах нь анхан шатны болон ерөнхий боловсрол үнэ төлбөргүй байвал зохино. Анхан шатны боловсролыг заавал эзэмшүүлэх ёстай.” гэж тус тус заажээ.

Улсын Их Хурлын гишүүн миний бие Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, 2024 оны 53 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын байршил, хүүхдийн тооноос хамааран өсөн нэмэгдэх итгэлцүүр”-тэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна.
Үүнд:

МОНГОЛ УЛСЫН ХУНИЙ ЭРХИЙН
ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА
Д.СҮНЖИД ТАНАА

- 2025000052

1. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Төрийн захирагааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журмын 2 дугаар зүйлд төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2 дахь жилээс (13-24 сар) 1 хувь, 3 дахь жилээс (25-36 сар) 2 хувь гэх мэтээр нэмэгдэж явсаар 25 дахь жилээс (289-300 сар) 24 хувь, 26 ба түүнээс дээш жил (301 ба түүнээс дээш сар) 25 хувийн нэмэгдлийг олгохоор заажээ. Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагчдын ажилласан жил бүрийг 1 хувиар нэмэгдүүлэн үнэлсэн атлаа 27, 28, 29, 30 жил гээд тэтгэвэрт гаран гартаа тогтол 25 хувиар нэмэгдэл авдаг. Энэ нь Монгол Улсын үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан хүний эрхийг зөрчиж байгаа эсэх талаар;
2. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 53 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар өсөн нэмэгдэх итгэлцүүр гэсэн хэрнээ Аймгийн төвийн сум болон нийслэлд байршилтай төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн тооноос хамаарах итгэлцүүрийг тогтоохдоо 2001-2500 суралцагчтай бол 0.91, 2501-3000 суралцагчтай бол 0.84, 3001-3500 суралцагчтай бол 0.82, 3500-аас дээш суралцагчтай бол 0.79 хувиар тооцож олгохоор бууруулан тооцсон байна. Судалгаанаас үзэхэд улсын хэмжээнд аймгийн төвийн сум, нийслэлд байршилтай төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургууль нийт 102 байх ба тэдгээрт суралцаж байгаа 300 гаруй мянган суралцагчид ногдох хувьсах зардал суралцагч тус бурд 9-21 хувиар буурсан байна. Мөн аймгийн төвөөс бусад суманд байршилтай төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн тооноос хамаарах итгэлцүүрийг тогтоохдоо 1200-аас дээш суралцагчтай бол 0.95-аар тооцохоор тусгасан байна. Энэ нь Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан хүний эрхийг зөрчиж байгаа эсэх дүгнэлтийг ;

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан хугацаанд бичгээр ирүүлэхийг хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Ц.МОНХТУЯА

- 2025000052